

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ, ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ  
АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 04 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус зөвлөлийн дөрвөн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, нэг гишүүнийг хуульд заасан үндэслэлээр эгүүлэн татаж байна. Эдгээр таван гишүүний гурвыг Улсын Их Хурлаас, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс болон Засгийн газраас тус бүр нэгийг нэр дэвшүүлэн томилсон байсан.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх саналаа Улсын Их Хуралд ирүүлэхийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг Төрийн байгуулалтын байнгын хорооноос зохион байгуулж, ирүүлсэн саналуудыг нэгтгэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Улсын Их Хуралд төрийн бус 20 байгууллагаас тус бүр 1 хүнийг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх санал ирүүлсэн байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар дээрх санал болгосон хүмүүсээс Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг нууц санал хураалтаар саналын хуудсаар авахад С.Алтанцэцэг, В.Бат-Эрдэнэ, Д.Батсүх нар хамгийн олон санал авсан.

Иймд С.Алтанцэцэг, В.Бат-Эрдэнэ, Д.Батсүх нарыг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулахыг дэмжих санал хураалт нэр дэвшигч тус бүрээр явуулахад гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч Д.Өлзийбаатарыг, Монгол Улсын Засгийн газар Н.Жанцан нарыг нэр дэвшүүлсэн байна. Эдгээр нэр дэвшигчдийг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Хуульд заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон А.Арман, Л.Пүрэвдорж, Д.Гоошоохүү, С.Мягмар, С.Санасэр нарыг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэж үзлээ.

Хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат нэр дэвшигч Д.Өлзийбаатар, Н.Жанцан нараас асуулт асууж, хариулт авсан болно.

Нэр дэвшигчийн танилцуулга болон холбогдох материалуудыг та бүхэнд тараасан.


Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**